



**“ДОРНОД НИЙТИЙН АЖ АХУЙ” ОНӨААТҮГ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

“Дорнод Нийтийн Аж Ахуй” ОНӨААТҮГ-ын үндсэн үйл ажиллагааг хангахад шаардлагатай Шатахуун тос, тосолгооны материалыг худалдан авахад энэхүү техникийн тодорхойлолтыг мөрдлөг болгоно.


- 1. Барааны тодорхойлолт:** Монгол Улсын болон Олон улсын стандартын шаардлага хангасан Дизель түлш болон авто бензин АИ-92, АИ-80 шатахууныг Захиалагч байгууллагад нийлүүлнэ. Үүнд холбогдох стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.
- 2. Стандарт:** Нийлүүлэх шатахуун АИ-92, АИ-80 авто бензин, дизель түлш нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа авто тээврийн хэрэгслийн шатахууны стандартын шаардлага /MNS 0216:2017-Дизель түлш Евро. Техникийн шаардлага, MNS 0217:2017-Хөдөлгүүрийн түлш. Этилжүүлээгүй бензин/-ыг хангасан байна.
- 3. Бараа худалдан авах газар, хэлбэр:** Нийлүүлэгч нь Шатахуун түгээх станцаар дамжуулан шатахууныг Захиалагчийн эзэмшилд бүртгэлтэй тээврийн хэрэгсэлд талоныг үндэслэн бэлэн бус хэлбэрээр олгож, Талууд сар бүр тооцоо нийлэн ажиллана.
- 4. Нийлүүлэгч:** Нийлүүлэгч нь Шатахуун түгээх станцаас түгээж байгаа шатахууны дээж болон шатахуун шахах автомат төхөөрөмжийн ажиллагааг сүүлийн нэг жилийн байдлаар итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн гэрчилгээ, дүгнэлтийг хавсарган ирүүлнэ.

Нийлүүлэгч нь аймгийн төвөөс гадна хөдөөгийн 13 суманд шатахуун түгээх салбар нэгжтэй байхаас гадна үнийн хувьд тохируулгатай байна.

Захиалагч байгууллагын шатахууны хэрэгцээг жилийн туршид найдвартай хангах бөгөөд зах зээл дээр шатахууны хомсдол гарсан тохиолдолд гэрээт байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй хангах шатахууны нөөцтэй байвал зохино. Бэлэн бусаар үйлчлэх нөхцөлийг хангана.

5. Худалдан авах шатахууны хэмжээ:

Д/д	Шатахууны төрөл	Хэмжих нэгж	Нийт үнийн дүн /төгрөгөөр/
1	АИ-92, АИ-80 автобензин	Литр	261,562,900
2	Дизель түлш, бусад шатах тослох материал	Литр	

Хянасан:
Ерөнхий нягтлан бодогч  Д.Ариунзаяа

Боловсруулсан
ТШҮА-ны дарга  Б.Марсболд